



2024

Annual Report

Агуулга

01	2024 онд Simple	03
02	Бидний философи, алсын хараа, эрхэм зорилго	04
03	Мэндчилгээ	05-06
04	2024 оны онцлох үйл явдлууд	07-08
05	Бизнесийн тойм	09
06	Санхүүгийн тойм /аудитлагдсан/	10-13
07	Харилцагчийн мэдээллийн төв	14
08	Эрсдэлийн удирдлага	15-18
09	Төлөөлөн удирдах зөвлөл	20
	• Шийдвэр, гүйцэтгэл	21-22
10	Компанийн бүтэц, зохион байгуулалт	24-27
	• Удирдлагын баг	24
	• Хүний нөөц	25-27

2024 онд Simple

Апп таталт

916.6 мянга

↑ 21.7% өсөлт

Цэвэр ашиг

23.7 тэрбум

↑ 121% өсөлт

Гэрээт харилцагч

122.2 мянга

↑ 16.5% өсөлт

Төлсөн татвар

7.5 тэрбум

↑ 102.7% өсөлт

Нийт хөрөнгө

346 тэрбум

↑ 65% өсөлт

Хүүний орлого

71 тэрбум

↑ 45% өсөлт

Ажилтнууд

106

↑ 23.2% өсөлт

Өөрийн хөрөнгийн өгөөж

31.9%

↑ 84.3% өсөлт

01



Бидний философи

Өөрийн цаг, мөнгө, энергийг чухал зүйлдээ л зориул.

02



Алсын хараа

№1 Дижитал зээлийн платформ.

03



Эрхэм зорилго

Харилцагчдынхаа цаг, мөнгө, энергийг хэмнэхэд зориулсан санхүүгийн хэрэгсэл байна.

ТУЗ-ийн даргын МЭНДЧИЛГЭЭ



Б.Билигүүн

ТУЗ-ийн дарга

Уламжлалт ББСБ-ын харилцааг шинэлэг бас инновацлаг бүтээгдэхүүн үйлчилгээ, технологийн дэвшлээр хялбаршуулж, хэрэглэгчдийнхээ санхүүгийн найз нь байсаар ирсэн Simple маань дөрөв дэх жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа хэрэглэгчид, хөрөнгө оруулагчид, түншүүддээ танилцуулах гэж байгаад таатай байна.

“Ухаалаг зарцуул” уриатай Simple маань энэ жил хэрэглэгчдэдээ илүү ойртож ажиллах үүднээс энэ жил Улаанбаатар хот даяар бизнес зээлийн нийт зургаан салбар болон Харилцагчдын үйлчилгээний төвийнхөө үүд хаалгыг цоо шинээр нээлээ. Үүгээр зогсохгүй манай улсын өнцөг бүрд суугаа иргэддээ санхүүгийн үйлчилгээг илүү хүртээмжтэйгээр хүргэх зорилгоор харилцагчийн гэрээгээ байгаа газраасаа зөвхөн гар утсаа ашиглан байгуулах боломжийг бий болгосондоо баяртай байна.

Бид 2023 онд анх Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO/IEC 27001:2013 стандартыг нэвтрүүлсэн билээ.

Харин энэ онд олон улсын магадлан итгэмжлэлийн SIS Certifications Pvt. Ltd байгууллагаас бидний энэхүү стандартыг бүхий л үйл ажиллагаандаа амжилттай, тасралтгүй хэрэгжүүлж буйг магадлах аудитаар баталгаажуулсан нь бид хэрэглэгчдийнхээ мэдээллийг найдвартай хадгалж, хамгаалж буйг илтгэсэн явдал болсон юм.

Ирэх жил ч бид эдгээр амжилтуудаа улам ахиулан, хэрэглэгчдэдээ зориулсан уян хатан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, тогтвортой хөгжлийн зорилтуудад илүү өргөн хүрээнд хувь нэмрээ оруулах чиглэлд илүү идэвхтэй үйл ажиллагаа явуулахаар зорьж байна.

Бидэнд үргэлж итгэн, дэмждэг та бүхэндээ баярлалаа.

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



П.Батжаргал

Гүйцэтгэх захирал

Хэрэглэгчдийнхээ цаг, мөнгө, энергийг ямагт хэмнэхийг зорьдог Simple дэх найзууд нь шинэ боломжууд, шинэлэг санаануудаар дүүрэн, амжилтаа улам илүү ахиулсан дөрөв дэх жилээ өнгөрүүллээ.

Энэ жил Simple-чүүд маань өнгөрсөн жилтэй харьцуулахад 14,2%-иар олуулаа буюу 122 мянгуулаа болсонд баяртай байна. Аппликейшн таталтын тоо 916,6 мянгад хүрч 21,7%-иар нэмэгдсэн бол манай цэвэр ашиг бидний түүхэнд хэзээ ч байгаагүйгээр буюу 121%-иар өсөж ₮23,7 тэрбумд хүрсэн үзүүлэлттэй байлаа. Ингэснээр бид энэ жил ч мөн өрсөлдөөн ихтэй финтекийн салбарынхаа тэргүүлэгчдийн нэг хэмээх байр сууриа хадгаллаа.


2023 онд манай хамт олон улсынхаа хөрөнгийн зах зээлийн түүхийн цоо шинэ хуудсыг нээж анхны зээлжих зэрэглэлтэй “Simple бонд”-ыг гарган ₮35 тэрбумыг татан төвлөрүүлж байсан бол энэ онд тус бондын III, IV, V ээлжийн захиалгыг эхлүүлж олон нийтээс ₮60 тэрбумын босгож хэрэглэгчдийнхээ цаг, мөнгө, энергийг хэмнэх бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдээ үргэлжлүүлэн хүргэхэд шаардлагатай эх үүсвэрүүдээ амжилттай татан төвлөрүүлж чадсан.

Үүгээр зогсохгүй бид одоогийн байдлаар Simple I болон II бондоо бүрэн хаасан бөгөөд үлдсэн дөрвөн бондын хөрөнгө оруулагчдынхаа өгөөжийг үргэлжлүүлэн хүртээсээр байна.

Хэрэглэхэд илүү хялбар бас ойлгомжтой, Simple-ийн дараагийн жилүүдийн өнгө төрхийг тодорхойлох Simple 3.0 хувилбараа нэвтрүүлсэн нь энэ жилийн хамгийн онцлох ажлуудын нэг байлаа. Энэхүү шинэчлэлийнхээ хүрээнд шинэлэг, инновацлаг бүтээгдэхүүн үйлчилгээнүүдээ ар араас нь нэвтрүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал, бид Малчны зээлийн бүтээгдэхүүнээ нэвтрүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр улсын өнцөг бүрд суугаа малчид маань зээл авах гэж малчны хотноосоо гарах шаардлагагүй болох юм. Үүнээс гадна бидний нэвтрүүлэхээр ажиллаж буй Микро зээлийн тусламжтайгаар нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй хувиараа бизнес эрхэлдэг иргэд маань зөвхөн сүүлчийн 6 сарын дансны хуулгаа Simple аппликейшн дээр оруулаад л зээлийн үйлчилгээ авах боломжийг олгох юм.


Өнөөдрийг хүртэл бидэнтэй хамт байгаа нийт Simple-чүүд болох манай хэрэглэгчид, хөрөнгө оруулагчид болон түншүүддээ баярлалаа.

2024 оны онцлох үйл явдлууд



Гэрэгэ киоск машинаар цахим зээлийн гэрээ хийх боломжтой болов

Simple аппликейшний бүртгэлээ үүсгэсэн шинэ хэрэглэгчид Гэрэгэ киоск машины орон даяарх 280 гаруй байршлаас өөрт хамгийн ойрыг сонгон харилцагчийн гэрээгээ ямар ч үнэ төлбөргүйгээр байгуулах боломжтой боллоо. Тодруулбал, Simple болон Гэрэгэ Системс компаниуд өнгөрөгч 3 сард байгуулсан хамтын ажиллагааныхаа хүрээнд уг үйлчилгээг нэвтрүүлсэн юм. Ингэснээр, Simple дэх найзууд нь гэрээ байгуулах цэгийнхээ тоог долоо дахин нэмэгдүүлж харилцагчдадаа улам бүр ойртож чадсан юм.



Цахим зээлийн гэрээгээ гар утаснаасаа байгуулдаг боллоо

Өмнө нь зээлийн эрхээ л байгаа газраасаа шалгаж, зээлийн хүсэлтээ илгээдэг байсан бол бид энэ жил цахим зээлийн гэрээгээ ч байгаа газраасаа байгуулах боломжийг бий болголоо. Ингэснээр зөвхөн аппаа татаад л хэрэгцээт зээлийн үйлчилгээгээ 100% гар утаснаасаа авах боломжтой боллоо.



Simple III бондыг арилжааг эхлүүлэв

Монголын анхны рейтингтэй буюу зээлжих зэрэглэлтэй Simple бондын III ээлжийн анхдагч зах зээл дэх арилжаа 6 сарын 7-нд нээгдэж 6 сарын 11-нд амжилттай хаагдлаа. Ингэснээр бид хэрэглэгчдийнхээ цаг, мөнгө, энергийг чухал зүйлдээ зарцуулахад нь туслах бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдээ илүү хүртээмжтэйгээр үргэлжлүүлэн хүргэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтаа татаж чадсан юм.



ISO/IEC 27001:2013 стандартыг амжилттай хэрэгжүүлж буйг баталгаажууллаа


Simple апп нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO/IEC 27001:2013 стандартыг өнгөрөгч 2023 онд нэвтрүүлсэн билээ. Харин энэ онд олон улсын магадлан итгэмжлэлийн SIS Certifications Pvt. Ltd байгууллагаас биднийг энэхүү стандартыг бүхий л үйл ажиллагаандаа амжилттай, тасралтгүй хэрэгжүүлж буйг магадлах аудитаар баталгаажуулж, 2024 оны 6 сарын 24-нд гэрчилгээ олголоо.



Зээлийн үйлчилгээг илүү хурдан хүргэх нөхцөл бүрдлээ


Simple дэх найзууд нь Дижитал Кредит компанитай хамтран LOS (Loan Origination System) буюу зээлийн өргөдөл боловсруулалт, олголтын илүү дэвшилтэт програмыг үйл ажиллагаандаа нэвтрүүллээ.

Энэхүү програмын тусламжтайгаар харилцагчдын бүртгэл, зээлийн өргөдлийн мэдээлэл бүрдүүлэлт зэрэг зээл олголтын бүхий л шат дамжлагуудаа автоматжуулж, харилцагчдадаа зээлийн үйлчилгээг илүү түргэн шуурхай, хүртээмжтэйгээр хүргэх нөхцөл бүрдлээ.




ТоС Холбоонд үндсэн гишүүнээр нэгдэв

Бид байгуулагдсан цагаасаа эхлэн байгальд хайртай байж, тогтвортой хөгжлийн санал санаачилгуудыг үйл ажиллагаатайгаа уялдуулан ажилласаар ирсэн. Харин энэ удаад эдгээр үйл ажиллагаагаа дараачийн түвшинд аваачих, тогтвортой хөгжлийн зорилтуудад илүү өргөн хүрээнд хувь нэмрээ оруулах, тогтвортой санхүүжилтийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ТоС Холбоо буюу Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоонд үндсэн гишүүнээр нэгдсэн шүү. Түүнчлэн бид тус холбооны тусламжтайгаар өөрсдийн үйл ажиллагаан дахь тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг бэхжүүлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад болон дотоодын эх үүсвэрээс ногоон хөрөнгө оруулалт татах зэрэг олон чиглэлүүдэд илүү идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломжтой боллоо.



Simple I болон II бондууд амжилттай төлөгдлөө

Энэ онд бид 2023 оны 7 болон 10 саруудад тус тус хөрөнгийн зах зээл дээр гаргаж байсан монголын анхны рейтингтэй Simple I, II бондуудынхаа хүүний болон үндсэн төлбөрийг бүрэн төлж хаасан юм. Энэхүү татан төвлөрүүлсэн эх үүсвэрүүд нь Simple-чүүдийн цаг, энерги, мөнгийг хэмнэхэд чиглэсэн олон бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг илүү хүртээмжтэйгээр үргэлжлүүлэн олгоход ихээхэн түлхэц болсон юм.



Simple 3.0 шинэчлэлийг танилцууллаа

Хэрэглэхэд илүү хялбар бөгөөд илүү ойлгомжтой, Simple-ийн дараагийн жилүүдийн өнгө, төрхийг тодорхойлох Simple 3.0 хувилбарыг нэвтрүүллээ. Ингэснээр Simple дэх найзууд нь хэрэглэгчдийнхээ цаг, мөнгө, энергийг улам бүр хэмнэх UI/UX, бүтээгдэхүүн үйлчилгээг дараагийн түвшинд аваачлаа.

 simple | 3.0



Бизнесийн ТОЙМ

Өмнөх онтой харьцуулахад 2024 онд зээлийн багц 79%-иар өсөж, гэрээт харилцагчдын тоо 14.3%-иар нэмэгдэн 122 мянгыг давжээ. Үүгээр зогсохгүй апп таталтын тоо 22%-иар өсөж нийт 916 мянга гаруй болж нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2024 оны хувьд бидний зүгээс шинэ өнгө төрх, хялбар хэрэглээ, уян хатан нөхцөл, найдвартай бөгөөд хурдан үйлчилгээг хүргэх Simple аппынхаа 3.0 хувилбарыг танилцуулсан. Зөвхөн дижитал зээлээс гадна бусад төрлийн зээлд анхаарч ажиллан хөрөнгө барьцаалсан зээлийн багцыг өнгөрсөн онтой харьцуулахад 358%-иар, автомашины зээлийг 532%-иар тус тус өсгөсөн үзүүлэлттэйгээр хуучин оноо үджээ. Үүнээс гадна бид хэрэглэгчдэдээ илүү ойртох үүднээс Харилцагчийн үйлчилгээний төв болон автомашины зээлийн зургаан салбарыг нээн ажиллаж байна.

Харин 2025 онд бид харилцагчдадаа дансны хуулгаараа хэрэглээний зээлийн эрхээ шалгах, худалдан авалтын зээлийг шинэчлэн хүргэх болон малчдад зориулсан зээлийн бүтээгдэхүүн зэрэг шинэлэг, инновацлаг бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулж, зээлийн багц мөн харилцагчдынхаа тоог нэмэгдүүлэхээр зорьж байна.

Гэрээтэй харилцагчид

106,964

122,197 +14.24%

Олгосон зээлийн тоо

286,174

223,481 -21.91%

Апп таталт

752,998

916,630 +21.7%

Олгосон зээлийн хэмжээ

411.3 тэрбум

666.2 тэрбум +62.02%

Зээл авсан харилцагчдын тоо

40,937

35,862 -12.4%

Зээлийн багц


161.4 тэрбум

297 тэрбум +79%


Санхүүгийн тойм /аудитлагдсан/

Бид 2024 онд Simple III, Simple IV, болон Simple V бондуудыг гаргаж 60 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлсэнтэй холбогдуулан нийт хөрөнгө 65%-иар, нийт зээл 79%-иар өссөн нь Банк бус санхүүгийн байгууллагийн салбарт нийт хөрөнгөөрөө гуравдугаарт, дижитал зээлийн багцаараа гуравдугаарт эрэмбэлэгдэж байна.

Нийт хөрөнгө /тэрбум төгрөгөөр/




Зээлийн багц /тэрбум төгрөгөөр/



Хөрөнгийн бүтэц /хувиар/


Хөрөнгийн бүтцийг харвал нийт хөрөнгийн 83%-ийг цэвэр зээлийн багц, 13%-ийг мөнгө ба түүнтэй адилтах хөрөнгө, үлдсэн 5%-ийг бусад хөрөнгө бүрдүүлж байна.



■	Зээл /цэвэр/	83%
■	Бусад хөрөнгө	3%
■	Мөнгө ба түүнтэй адилтах хөрөнгө	12%
■	Хуримтлагдсан хүүний авлага	2%


Эх үүсвэрийн бүтэц /тэрбум/

2024 оны байдлаар нийт эх үүсвэрийн 75%-ийг өр төлбөр, 25%-ийг эздийн өмч эзэлж байна.



Хүүний орлого ба зарлага /тэрбум/


Өмнөх онтой харьцуулахад 2024 онд манай компанийн хүүний орлого 45%-иар, хүүний зардал 50%-иар тус тус өссөнөөр цэвэр хүүний орлого 39 тэрбум төгрөгт хүрсэн байна.



Орлогын бүтэц /хувиар/



Зардлын бүтэц




Хүний зардал	64.2%
Үйл ажиллагааны зардал	24.8%
Эрсдэлийн сангийн зардал	0.2%
Татварын зардал	9.8%
Шимтгэл хураамжийн зардал	1%


Цэвэр ашиг /тэрбум төгрөгөөр/

2024 онд Ашид Капитал ББСБ нь 23.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оноос 121%-иар өссөн үзүүлэлт бөгөөд өөрийн хөрөнгийн өгөөж 31.9%-д хүрсэн байна.

Цэвэр ашиг



Өөрийн хөрөнгийн өгөөж



Харилцагчийн мэдээллийн төв

Бид хэрэглэгчдийнхээ санхүүгийн туслах, үнэнч найз нь байхын тулд асуулт болгонд хариулт өгч, тодорхойгүй нөхцөл байдал бүрд нь тусалж, зөвлөхийг хичээн ажилладаг. Уг зорилгынхоо хүрээнд 1800-2828 тусгай дугаар, и-мэйл, фэйсбүүк пост, коммент, чат, “Simple хэрэглэгчдийн групп” зэрэг сувгуудаар ирсэн зээлийн үйлчилгээ, аппликэйшн ашиглалт, бусад үйлчилгээний лавлагааг амжилттай үзүүлж байна.



87,173

Амжилттай
дуудлага



17,293

Сошиал сувгаар
үйлчилсэн



99%

Гомдол
шийдвэрлэлт



2,043

И-мэйлээр
үйлчилсэн



160,460

IVR мэдээлэл авсан



1:36

Ярианы дундаж
минут


Эрсдэлийн удирдлага

Simple-ийн эрсдэлийн удирдлагын засаглал нь хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хүрээнд бизнест ээлтэй, зохистой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, эрсдэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих, хэрэгжилтийг хангуулах, хяналт тайлагналтын тэнцвэртэй тогтолцоог бий болгоход оршдог.

Бид эрсдэлийн удирдлагын бодлогоороо компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, түүний оролцогч талуудын үүрэг хариуцлага, эрсдэлийн хамрах хүрээ, төрлийг тодорхойлдог.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Компани нь эрсдэлийн удирдлага тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэхдээ хамгаалалтын гурван бүсийн зарчмыг мөрдлөг болгон үүрэг хариуцлагыг хуваарилан ажиллаж байна.



Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээ

Бид жил бүр стратегийн зорилт болон бизнесийн төлөвлөгөөндөө хүрэхэд учирч болох хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээ, гол эрсдэлийн үзүүлэлтийг батлан, үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээ нь Simple-ийн эрсдэл даах чадварын хүрээнд буюу хууль тогтоомж, зохицуулагч байгууллагаас тогтоосон хязгаарлалтын хүрээнд байдаг.

2024 онд эрсдэлийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг санхүүгийн эрсдэлийн 12 үзүүлэлт, санхүүгийн бус эрсдэлийн 11 үзүүлэлтээр батлан, түүнд сар бүр хяналт тавьж, тайлагнан ажиллалаа.

Эрсдэлийн төрөл болон эрсдэлийн үзүүлэлтийн тоо

Эрсдэлийн төрөл	Эрсдэлүүд	2024
Санхүүгийн эрсдэл	Зээлийн эрсдэл	2
	Зээлийн төвлөрлийн эрсдэл	5
	Зах зээлийн эрсдэл	2
	Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл	2
	Хөрвөх чадварын эрсдэл	1
Санхүүгийн бус эрсдэл	Үйл ажиллагааны эрсдэл	3
	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл	3
	Ёс зүйн эрсдэл	3
	Хянан нийцүүлэлтийн эрсдэл	2

Зээлийн эрсдэлийн удирдлага

Simple нь 2024 онд чанартай зээлийн багцын тогтвортой өсөлтийг анхаарч, хамгаалалтын гурван бүсийн зарчмыг хэрэгжүүлж, нэгжүүдийн чиг үүрэг, зээлийн эрсдэлийн удирдлага, хяналтыг сайжруулан ажиллалаа.

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС-9)-д нийцүүлэн ББСБ-ын зээлийн багцын үнэ цэнийн бууралт тооцох аргачлал, журам зааврыг сайжруулан, зээлийн багцын үнэ цэнийн бууралтыг тооцсон.

Бид зээлийн үйл ажиллагаандаа скорингийн загварыг ашиглан харилцагчийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, зээлжих зэрэглэлийг тогтоодог бөгөөд скорингийн загварын үр дүнг буцаан шалгах, шинэчлэн сайжруулах ажил тогтмол хийгдэж, 2024 оны 4-р улиралд скорингийн загварын ээлжит сайжруулалтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Мөн зээлийн эрсдэлийг шинжлэн, зах зээлийн хэвийн болон хэвийн бус нөхцөл байдалд тооцоолох, зээлийн эрсдэлийг үнэлэх арга аргачлалуудыг сайжруулан ажиллаж байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд төлбөрийн зөрчилтэй зээлийг эргэн төлүүлэх ажиллагаанд ажлын зохион байгуулалт, бүтцийг сайжруулснаар хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, чанаргүй зээлийн өсөлтийг зогсоож, багцын чанарыг хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээнд хангаж ажиллалаа.

Зээлийн эрсдэлийн удирдлагын үндсэн зарчмууд болох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийн хяналтын самбар, тайлагналын системийг сайжрууллаа.



Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Simple нь 2024 онд үйл ажиллагааны эрсдэлийг удирдахдаа баримтлах “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”-ыг батлан, мөрдлөг болгон ажиллаж байна. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд компанийн онцлогт нийцүүлэн Эрсдэл хяналтын өөрийн үнэлгээний аргачлал (Risk and Control Self-Assessment)-ыг боловсруулан баталсан бөгөөд аргачлалын дагуу учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, үнэлэн, түүнд үр дүнтэй хариу арга хэмжээг төлөвлөн ажиллалаа.

Мөн эрсдэлийн тохиолдлыг мэдээлэх сувагчлалыг дотоод системд хөгжүүлэн, нийт ажилтнууд эрсдэлийн тохиолдлыг цаг алдалгүй мэдээлэх боломжоор хангаад байна.

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

Simple нь харилцагчдынхаа мэдээллийг алдагдахаас сэргийлэх, тэдгээр эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах зэрэг арга хэмжээг олон улсын стандарт, Монгол улсын холбогдох хууль журамд амжилттайгаар нийцүүлэн ажилладаг бөгөөд Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO/IEC 27001:2013 стандартыг 2023 онд нэвтрүүлсэн билээ.

2024 онд биднийг энэхүү стандартыг бүхий л үйл ажиллагаандаа амжилттай, тасралтгүй хэрэгжүүлж буйг олон улсад магадлан итгэмжлэгдсэн байгууллагаас баталгаажуулаад байна.

Бид Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг удирдлагыг хэрэгжүүлэхдээ компанид мөрдөгдөх Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг батлан, мэдээллийн хөрөнгөд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж үнэлэн, эрсдэлд хариу арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бид Гуравдагч байгууллагаар Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэж, эмзэг байдлыг бууруулах үйл ажиллагааг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна.





 simple | buy



Төлөөлөн удирдах зөвлөл

“Ашид Капитал ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үндсэн 4 гишүүн болон 1 хараат бус гишүүнтэйгээр ажилладаг бөгөөд Монгол улсад мөрдөгдөж буй Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, зохицуулагч байгууллагаас батлан гаргасан холбогдох журам заавар болон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.



Гаргасан шийдвэрүүд

	Тогтоолын нэр	Огноо	Дугаар
1	Журам батлах тухай	2024.02.05	1
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүн батлах тухай	2024.02.05	2
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам батлах тухай	2024.02.05	3
4	Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай	2024.02.05	4
5	2024 оны гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг батлах тухай	2024.02.05	5
6	2023 оны гүйцэтгэлийг үнэлэх тухай	2024.02.05	6
7	Компанийн зохион байгуулалтын бүтэц болон орон тооны дээд хягаар батлах тухай	2024.02.05	7
8	Салбар, нэгж байгуулах зөвшөөрөл олгох тухай	2024.02.05	8
9	Төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл олгох тухай	2024.03.01	9
10	Салбар, нэгж байгуулах зөвшөөрөл олгох тухай	2024.03.13	10
11	Салбар, нэгж байгуулах зөвшөөрөл олгох тухай	2024.03.13	11
12	Салбар, нэгж байгуулах зөвшөөрөл олгох тухай	2024.03.13	12
13	Салбар, нэгж байгуулах зөвшөөрөл олгох тухай	2024.03.13	13
14	Салбар, нэгж байгуулах зөвшөөрөл олгох тухай	2024.03.13	14
15	Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай	2024.05.13	15
16	Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай	2024.05.24	16
17	Зээл авах зөвшөөрөл олгох тухай	2024.06.12	17
18	Өрийн бичиг гаргах тухай	2024.06.12	18
19	Өрийн бичиг гаргах тухай	2024.06.12	19
20	Зээл авах зөвшөөрөл олгох тухай	2024.06.12	20
21	Ёс зүйн дүрэм батлах тухай	2024.08.29	21
22	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам болон дотоод хяналтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай	2024.08.29	22
23	Өрийн бичиг гаргах тухай	2024.09.09	23


Гаргасан шийдвэрүүд

	Тогтоолын нэр	Огноо	Дугаар
24	Зээл авах зөвшөөрөл олгох тухай	2024.09.09	24
25	Зээлийн шугамын эрх нээлгэх тухай	2024.09.25	25
26	Зээлийн шугамын эрх нээлгэх тухай	2024.09.25	26
27	Зээл авах зөвшөөрөл олгох тухай	2024.09.25	27
28	Зээлийн шугамын эрх нээлгэх тухай	2024.10.24	28
29	Зээлийн шугамын эрх нээлгэх тухай	2024.10.24	29
30	Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл олгох тухай	2024.10.24	30
31	Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл олгох тухай	2024.11.14	31
32	Гүйцэтгэх захиралд эрх олгох тухай	2024.12.18	32
33	Эрсдэлийн аппетит шинэчлэн батлах тухай	2024.12.18	33
34	Мэдээлэл аюулгүй байдлын бодлого шинэчлэн батлах тухай	2024.12.18	34
35	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны сургалтын төлөвлөгөө батлах тухай	2024.12.18	35
36	Компанийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай	2024.12.18	36
37	Компанийн төсөв, төлөвлөгөө батлах тухай	2024.12.18	37
38	Компанийн бизнес төлөвлөгөө батлах тухай	2024.12.18	38
39	Зээл авах зөвшөөрөл олгох тухай	2024.12.18	39
40	Зээл авах зөвшөөрөл олгох тухай	2024.12.18	40
41	Зээл авах зөвшөөрөл олгох тухай	2024.12.18	41
42	Зээл авах зөвшөөрөл олгох тухай	2024.12.18	42
43	Зээл авах зөвшөөрөл олгох тухай	2024.12.18	43
44	Зээл авах зөвшөөрөл олгох тухай	2024.12.18	44
45	Салбар, нэгж байгуулах зөвшөөрөл олгох тухай	2024.12.18	45

 simple | plus



Компанийн бүтэц, зохион байгуулалт



Удирдлагын баг



П.Батжаргал

Гүйцэтгэх захирал




С.Сайнбилигт

Эрсдэлийн удирдлагын
хэлтсийн захирал



Н.Эрдэнэтунгалаг

Санхүү бүртгэл, тайлагналын
хэлтсийн захирал



Г.Мөнхбаясгалан

Санхүү удирдлага, хөрөнгө
зохицуулалтын хэлтсийн захирал



Н.Буянзаяа

Бизнес зээлийн төвийн
захирал



Г.Цэлмүүн

Маркетингийн хэлтсийн дарга



Б.Энхмандах

Хууль, комплаенсийн
хэлтсийн дарга



Д. Энхбаатар

Мэдээллийн технологийн
дэд бүтцийн албаны менежер



Б.Энхбилгүүн

Борлуулалт харилцагчийн
үйлчилгээний албаны дарга



Б.Энхтүвшин

Хүний нөөцийн
хэлтсийн менежер



Б.Баттулга

Мэдээллийн технологийн
хөгжүүлэлтийн албаны дарга

Хүний нөөц

Бид компанийн эрхэм зорилго, үнэт зүйлс, баримтлах зарчимд тулгуурлан шударга ёс, жендерийн тэгш эрхийг хангасан нээлттэй бодлогыг баримтлан, Монгол улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль, журмын дагуу ажилладаг. Олон ургалч, ялгаатай байдлыг хүндэлж, бүх ажилтнуудтайгаа эн тэнцүү харьцаж, хүн нэг бүрийн хүчин зүтгэл, оролцоог дэмждэг. Шинэ цагийн хөгжил, технологийн дэвшил, дэлхийн чиг хандлагатай хөл нийлүүлэн, тасралтгүй хөгжиж, бие биеэсээ суралцаж, мэдлэг чадвараа ахиулах боломжийг ажилтнууддаа олгохыг зорин ажиллаж байна. Бидний хэрэгжүүлдэг удирдлагын зохион байгуулалтын хөндлөн (флат) бүтэц нь шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлж, дотоод процессыг илүү уян хатан болгосноор ажлын нээлттэй орчныг бий болгож, ажилтнуудад чөлөөтэй сэтгэх, санал санаачилгаа хэрэгжүүлэх тухтай нөхцөлийг бүрдүүлдэг. Программ хөгжүүлэлтийн шинэлэг арга барил болох agile аргыг нэвтрүүлж, дэлхийн зах зээл дээрх хамгийн сүүлийн үеийн технологийг цаг алдалгүй өөрсдийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд туршиж, хөгжүүлэлтийн хамгийн оновчтой аргыг нэвтрүүлж, улам бүр сайжруулан ажилласаар байна.



Шинээр орж буй ажилтанд “Халамжлагч ажилтан”-г томилон “Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлдэг.

Тасралтгүй суралцах нөхцөлийг бүрдүүлснээр байгууллагын чадамжийг нэмэгдүүлэх зорилготой 150 гаруй танхимын болон зайны сургалтад 50 орчим дотоод мэргэшсэн сургагч багш нар мэргэжлийн болон ерөнхий ур чадварын сургалтуудыг зохион байгуулж хамтран ажилладаг бөгөөд ажилтнуудад суралцахын хажуугаар группийн хэмжээнд танилын хүрээгээ тэлэх боломжийг ч олгодог. 2024 онд давтагдсан тоогоор манай компанийн 148 ажилтан нийт 150 гаруй сургалтаас сонгон 1,091 цагийн сургалтанд хамрагдсан байна.



Бид жил бүр ажилтан бүрээс соёлын судалгаа авч судалгаанд суурилсан дүн шинжилгээ хийн хүний нөөцийн үйл ажиллагаагаа тогтмол сайжруулах арга хэмжээ авч ажилладаг. Тус судалгааны үр дүн дээр үндэслэн 2024 онд байгууллагын эерэг соёлыг хадгалах, ажилтнуудын сэтгэл ханамжийг улам нэмэгдүүлэх зорилготой спорт, урлагийн чөлөөт үйл ажиллагаануудыг тогтмол зохион байгуулж ажилтнуудын чөлөө цагаа зөв, боловсон өнгөрөөх нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа.

Дадлагын хөтөлбөрийн хүрээнд цалинтай дадлагажигч оюутан ажиллуулж цаашлаад харилцан тохиролцсоны дагуу үндсэн ажлын байраар хангаж байна.

MCS группийн хэмжээнд хэрэгжсэн оюутны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд бид нийт 8 оюутанд сургалтын төлбөрийн тэтгэлэг олголоо.

Сонирхлын клубууд байгуулж тэдгээрийг дэмжин ажиллалаа.

Simple-ийн ажилтнууд дараах хөнгөлөлт урамшууллыг эдэлдэг:



Хуримын бэлэг /тухай бүр/



Шинэ хүүхдийн бэлэг /тухай бүр/



Бүтээгдэхүүн худалдан авах хөнгөлөлт /сар бүр/



Өндөр настны тэтгэмж /тэтгэвэр тогтоолгох үед нэг удаа/



Ажилтны хөнгөлөлттэй зээл /тухай бүр/



Ахмад ажилтны бэлэг /жилд нэг удаа/.

Нийт ажилтнуудын тоо

106

Дундаж нас

29

Эмэгтэй

49%

Эрэгтэй

51%

Бидний үнэт зүйлс

Өөрөөр сэтгэдэг

Хэвшмэл байдлыг сорьж, шүүмжлэлийг нээлттэй хүлээн авна. Эцэст нь, өөрчлөлт бол бидний хийх бизнес.

Өөрөөрөө

Simple нь төгс биш, өвөрмөц хүмүүсээс бүрддэг. Харах өнцөг, харагдах байдлаас үл хамааран нэг нэгнээ хүлээн зөвшөөрдөг. Ажил дээр өөрөөрөө байж, бусдадаа ч гэсэн өөрөөрөө байх орчинг бүрдүүлээрэй.

Өөриймсөг

Шинэ санаа, сайн процесс чухал ч, ажлынхаа гүнд орж, ард гарах нь амжилт. Сэтгэлээ зориулан бүтээсэн бүхэн бидний амжилтыг тодорхойлдог.

ӨӨӨ,

Алдахаас битгий ай, алдаагаа давтах нь л алдаа.



📍 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сэнтрал Тауэр 5 давхар, 509-510 тоот

📞 1800-2828

🌐 simple.mn

📘 📷 SimpleMGL